

## Зүүн Азийн Слав болон Еврази судлалын олон улсын зургадугаар бага хурал боллоо

\\БНСУлс, Сөүл, 2014.06.26-27\\

Дэлхийн Төв болон Зүүн Европ Судлалын Олон Улсын Холбооны шугамаар 2007 оноос жил бүр зохион байгуулагддаг Зүүн Азийн Слав болон Еврази судлалын зургадугаар бага хурал 2014 оны 6 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Сеүл хотноо амжилттай боллоо. Тус хурлыг БНСУ-ын Слав Судлалын Холбоо /KASS - Korean Association for Slavic Studies\ хариуцан Ханкукийн Гадаад Судлалын Их Сургуульд зохион явууллаа. Тус хурлын үеэр 29 сэдвээр салбар чуулган болж 80 илтгэл хэлэлцэн сонссон ба нийт 13 орны 180 эрдэмтэн судлаачид илтгэгч, чуулган даргалагч, шүүмжлэгчийн хувиар оролцлоо. Энэ нь Зүүн Азийн Слав болон Еврази Судлалын бага хурлын түүхэнд хамгийн олон оролцогчтой хурал байсан гэж Солонгосын Слав Судлалын Холбоо тус хурлын дараах мэдээндээ онцлон тэмдэглэжээ.

Тус бага хурал “Зүүн Азид энх тайвныг тогтоох ба Евразийн хамтын ажиллагаа: Эрч хүч ба Зорилт” ерөнхий сэдвийн дор чуулав. БНСУ-ын Слав Судлалын Холбооны Ерөнхийлөгч Дукжун Чанг бага хуралд илгээсэн мэндчилгээндээ: “Хүйтэн дайн” шувтарснаас хойш Евразийн тивд оршин амьдарч буй улс орнууд шилжилтийн үеийн өөрчлөлт хөдөлгөөнд өртсөн. Нэг талаас, Еврази тив ялангуяа, Зүүн Азийн бүс нутагт томоохон гүрнүүд сөргөлдөх байр

## ОЛОН УЛС СУДЛАЛ

суурь баримтлан, тэдний өөрсдийн ашиг сонирхлоо илэрхийлэх өрсөлдөөний талбар болсон. Нөгөө талаас, Еврази болон Зүүн Азийн улс орнууд аюулгүй байдлын асуудлаар хүчин чармайлтаа нэгтгэх, эдийн засаг-соёлын хамтын ажиллагааг идэвхжүүлэн энх тайванч, цэцэглэн хөгжиж буй Еврази тивийг цогцлоон бүтээхэд хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааг зохистой байдлаар өрнүүлж буй Еврази тивийг төлөвшүүлэхийн тулд БНСУ-лс “Евразийн санаачилга”, Орос ба Хятад Улс нь “Евразийн тулах цэг”, “Шинэ Торгоны Зам” нэртэй санал санаачилгыг дэвшүүлээд байна. Тус бага хурал нь эрдэмтэн судлаачдын бүтээлч, үр ашигтай санал, байр суурь илэрхийлэх, туршлага солилцох индэр болон Еврази тивийг хөгжингүй, сонирхол татахуйц газар болгоход хувь нэмрээ оруулж, харин оролцогч судлаачдын хувьд академик ач холбогдолтой, үнэ цэнэтэй саналаа хэлэх арга хэмжээ болно” гэдэгт итгэж байгаагаа онцлон хэлсэн.

Зүүн Азийн Слав болон Еврази судлалын зургадугаар бага хуралд Төв болон Зүүн Европ Судлалын Монголын Холбоог \ТЗЕСМХ\ төлөөлөн гүйцэтгэх захирал, ШУА-ийн ОУСХ-ийн Орос судлалын салбарын ахлах судлаач доктор \PhD\, проф. Д.Алтай оролцож салбар хуралдаан удирдаж, илтгэл тавив. ТЗЕСМХ-олбоо 2012 онд байгуулагдсан бөгөөд 2013 оны наймдугаар сард Олон Улсын Холбоонд \ICSEES\ гишүүнээр элсэж, Японы Осака хотноо 2013 оны наймдугаар сарын 9-10-ны өдрүүдэд болсон Зүүн Азийн Слав болон Еврази судлалын тавдугаар бага хуралд анхлан оролцсон. Тус бага хурлын үеэр Зүүн Азийн орнуудын Слав судлалын Холбоодын дээд хэмжээний уулзалт \Summit of Slavicist Associations in East Asia\ болдог зургадугаар бага хурлын өмнөх өдөр \2014 оны 6 дугаар сарын 26 д\ Сеул хотод болсон ба монголын төлөөлөгч түүнд оролцсон. Энэ хурлаар дараах асуудлыг хэлэлцэж тохирсон. Үүнд :

1. 2015 онд Токиогийн ойролцоо Макухари хотод Дэлхийн ICSEES Холбооны есдүгээр их хурал 2015 оны 8 дугаар сарын 3-8-ны өдрүүдэд зохион байгуулагдах тул 2015 онд Зүүн Азийн Слав болон Еврази Судлалын ээлжит бага хурлыг зохион байгуулалгүй

өнжих шийдвэр гаргав. Анх удаа Ази тивд болох Дэлхийн Слав судлалын Их хуралд Монголын талаас 3 судлаач оролцохоор бүртгүүлээд байна. Үүнд ОУСХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор \PhD\ А.Нямдолжин, Орос судлалын ахлах судлаач доктор \PhD\ К.Дэмбэрэл, Д.Алтай нар оролцон илтгэл тавих юм.

2. 2016 оны Зүүн Азийн Слав болон Еврази судлалын долоодугаар бага хурлыг БНХАУ-ын Төв Ази, Зүүн Европ, Орос судлалын Хятадын Холбоо хариуцан Шанхай хотноо зохион явуулахаар шийдвэрлэв. Монголын Холбооноос ойрын ирээдүйд Зүүн Азийн Слав болон Еврази Судлалын ээлжит бага хурлыг Улаанбаатарт зохион явуулах саналыг дахин хөндсөн ба Д.Алтай 2016 онд Монголд УИХ-ын ба орон нутгийн сонгууль болох тул боломж багатай харин 2017 оноос цааш Монгол Улсад зохион байгуулах сонирхол бий гэсэн тодруулгыг өгсөн.

3. Зүүн Азийн орнуудын Төв болон Зүүн Европ судлалын Холбоодын дээд хэмжээний уулзалтаас энэхүү бүтцийг институтчилэх \албан ёсны болгох\ саналыг Солонгосын Слав Судлалын Холбоо дэвшүүлж уг асуудлыг нухацтай хэлэлцэв. Энэхүү хуралд БНСУ, БНХАУ, Япон, Монгол Улс, Казахстаны Төв болон Зүүн Европ судлалын үндэсний Холбоодын төлөөлөгчид оролцов. Энэхүү байгуулах шинэ бүтцийн Дүрмийн төслийг Зүүн Азийн Слав болон Еврази судлалын бага хурлыг анхлан 2007 онд санаачилсан Япон, Хятад, БНСУ-ын Холбоодын төлөөллийг оролцуулан Солонгосын Холбоо хариуцан боловсруулж, Зүүн Азийн бүс нутгийн орнуудын Слав болон Еврази Судлалын Холбоодод цахим хэлбэрээр илгээн, санал аван нэгтгэхээр тохиролцов. Асуудлыг дараагийн дээд хэмжээний хурлаас эцэслэн шийдвэрлэхээр болов.

Зүүн Азийн Слав болон Еврази судлалын зургадугаар бага хуралд Монголын төлөөлөгч Д.Алтай эхний өдөр “Евразид Шударга ёс тогтоон, Улс төр-Эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” сэдэвт салбар чуулганыг удирдсан ба ОХУ, Итали, Японы эрдэмтэдийн илтгэлийг хэлэлцэв. Харин хоёрдахь өдөр “Зүүн ба Зүүн Өмнөт Ази дахь Орос Улс” сэдэвт салбар чуулганд илтгэгчийн хувиар оролцон “ICCEES Холбооны хүрээнд судлаачид

## *ОЛОН УЛС СУДЛАЛ*

ойрын ирээдүйд хамтран ажиллах зарим чиглэл” сэдвээр мэдээлэл хийв. Энэ хуралдаанд Унгар, БНСУ-ын судлаачид оролцон илтгэл тавив.

Тус олон улсын бага хурал нь оролцогчдын хувьд шинэ мэдээлэл олж авах, арга зүй, туршлага нэмэхэд чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

*Мэдээ бэлтгэсэн Д.Алтай 2014.09.08*